



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 17 өдөр

Дугаар А/606

Ховд

Газар өмчлөх эрх шилжүүлэх тухай

Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.3, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дахь заалтуудыг үндэслэн Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2005 оны 07 дүгээр сарын 27-ны өдрийн 175 дугаар захирамжаар гэр бүлийн хамтын хэрэгцээнд дундаа хамтран газар өмчилсөн иргэдийн хэлцлийг харгалзан Жаргалант сумын Хайрхан багийн 1-356 тоот 936,0м² хэмжээтэй, 2340000 төгрөгийн үнэ бүхий газрыг иргэн Довдонбазарын Түмэнжаргалд, аймгийн Засаг даргын 2005 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 115 дугаар захирамжаар гэр бүлийн хамтын хэрэгцээнд дундаа хамтран газар өмчилсөн иргэдийн хэлцлийг харгалзан Жаргалант сумын Бичигт багийн 4-9 тоот 1200,0м² хэмжээнтэй, 3000000 төгрөгийн үнэ бүхий газрыг иргэн Цэрэнбатын Тунгалагт, аймгийн Засаг даргын 2004 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 266 дугаар захирамжаар гэр бүлийн хамтын хэрэгцээнд дундаа хамтран газар өмчилсөн иргэдийн хэлцлийг харгалзан Жаргалант сумын Алагтолгой багийн 2-10 тоот 792,0м² хэмжээтэй, 980000 төгрөгийн үнэ бүхий газрыг иргэн Ганьдын Даваагалсанд, аймгийн Засаг даргын 2007 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 179 дүгээр захирамжаар гэр бүлийн хамтын хэрэгцээнд дундаа хамтран газар өмчилсөн иргэдийн хэлцлийг харгалзан Жаргалант сумын Наран багийн 22-10 тоот 1100м² хэмжээтэй, 2750000 төгрөгийн үнэ бүхий газрыг иргэн Цэцэнготовын Цолмонбаатарт тус тус үнэ төлбөргүйгээр шилжүүлэн өмчлүүлсүгэй.

Зах А/606 617
02 03007

2.Дээрх нэр бүхий иргэдэд шилжүүлсэн газарт хуулийн дагуу хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын дарга /Б.Баярсүх/, Улсын бүртгэлийн хэлтсийн дарга /Хоролсүрэн/ нарт үүрэг болгосугай.


3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2005 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 175 дугаар захирамжийн 159,161,162 дох заалт буюу Х.Цэндсүрэн, Ц.Цэнд-аюуш, Ц.Сүрэнжав нарт холбогдох хэсгийг, аймгийн Засаг даргын 2005 оны 05 дугаар сарын 16-ний өдрийн 115 дугаар захирамжийн 87, 88, 89, 90 дэх заалтыг, аймгийн Засаг даргын 2004 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 266 дугаар захирамжийн 65,66,67,68,69 дэх заалтад холбогдох хэсгийг, аймгийн Засаг даргын 2007 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 179 дүгээр захирамжийн 22 дахь заалтын М.Алтансүвд, Ц.Номуунжаргал, Ц.Баянжаргал нарт холбогдох хэсгийг тус тус хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2019 оны
9 дүгээр сарын 17-ны өдрийн А/606 дугаар
захирамжийн хавсралт



ГЭР БҮЛИЙН ХЭРЭГЦЭЭНИЙ ГАЗАР ӨМЧЛӨХ ЭРХЭЭ НЭГ ГИШҮҮНДЭЭ
ҮНЭ ТӨЛБӨРГҮЙГЭЭР ШИЛЖҮҮЛСЭН ИРГЭДИЙН ЖАГСААЛТ

Овог нэр	Хаяг	Газрын хэмжээ /м2/	Газар өмчилж авсан захирамжийн огноо	Дугаар	Хавсралтанд орсон дугаар
Довдонбазар Түмэнжаргал	Хайрхан баг 1-35 б тоот	936,0	2005-07-27	175	159-162
Цэрэнбат Тунгалаг	Бичигт баг 4-9 тоот	1200,0	2005-05-16	115	86-90
Ганьд Даваагалсан	Алагтолгой баг 2-10 тоот	792,0	2004-11-12	266	64-69
Цэцэнготов Цолмонбаатар	Наран баг 22-10 тоот	1100,0	2007-07-06	179	22